



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

БҮТЭЭЛИЙН ХУУЛБАРЛАЛТ ШАЛГАХ, “БҮТЭЭЛИЙН ХУУЛБАРЛАЛТЫГ ИЛРҮҮЛЭХ СИСТЕМ” АШИГЛАХ ЗААВАР

2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирал

1. Үйл явцын дараалал

- 1-р алхам:* Суралцагч өөрийн судалгааны ажлыг зааврын дагуу шалгаж “Баталгааны хуудас” /Хавсралт 2/-ыг бөглөж удирдагч багшид илгээнэ.
- 2-р алхам:* Суралцагчийн өөрийгөө шалгасан “Баталгааны хуудас”-ыг удирдагч багш хянаж албан и-мэйл хаягаасаа баталгаажуулан АТС-ийн grad_research.num.edu.mn, (Сс: [суралцагчийн и-мэйл](mailto:grad_research@num.edu.mn)) хаягаар 2021 оны 05 дугаар сарын 24-ний дотор ирүүлнэ.
- 3-р алхам:* АТС эцсийн байдлаар хянаж тухайн суралцагчийг дипломын жинхэнэ хамгаалалтад оруулахыг дэмжих эсэх тухай тодорхойлолтыг хамгаалуулах зөвлөлд хүргүүлнэ.
- 4-р алхам:* Хамгаалуулах зөвлөлийн комисс АТС-иас ирсэн бичгийг үндэслэн суралцагчийг дипломын жинхэнэ хамгаалалтад орох зөвшөөрлийг олгоно.



2. Санамж


- 45%-иас дээш хувийн давхцал илэрсэн тохиолдолд бүтээлийн хуулбарлалт хийгдсэн гэж үзнэ. Энэ тохиолдолд суралцагчийг судалгааны ажлын бичвэртээ сайжруулалт хийх, давхцалыг арилгах арга хэмжээ авч, дахин шалгахыг шаардана.
- Хэрэв системийн хувьд зөрчилдөөнтэй гэж үзвэл бичвэрийг эх баримтын ижил төсөөтэй хэсэг тус бүрээр шалтгааныг тайлбарлаж бичнэ.
- Давхцалын хэмжээ 85% ба түүнээс дээш бөгөөд суралцагч давхцалыг арилгах тал дээр ямар нэгэн арга хэмжээ аваагүй, тайлбар хариу ирүүлээгүй тохиолдолд бүтээлийн хуулбарлалт хийсэн гэж үзэж хамгаалуулах зөвлөлд уламжилна.
- Диплом хамгаалалтын өмнө буюу заасан хугацаанд бүтээлийн хуулбарлалтыг шалгаж ирүүлээгүй суралцагчийг хамгаалалтад орохыг дэмжихгүй.

3. Бүтээлийн хуулбарлалт шалгах заавар

Энэ систем бүтээлийн хулгай агуулсан байх магадлалтай сэжигтэй баримтыг бүтээлийн сангаас шалгаж бүтээлийн хулгайг таамаглан харуулна. Системд <http://pds.num.edu.mn> хаягаар хандаж ашиглана.

4. Хэрэглэгчээр нэвтрэх

Сэжигтэй баримтыг шалгах, бүтээлийн санд баримтыг индексэлж оруулахдаа хэрэглэгчээр нэвтэрсэн байх шаардлагатай. Үүний тулд МУИС-ийн багш, ажилчдын СиСи эрхийг ашиглана. Системд анх хандахад дараах зурагт үзүүлсэн нүүр хуудас харагдана.



Зураг 1. БХС системийн нүүр хуудас

Нэвтрэх товчийг дарахад СиСи хэрэглэгчийн нэвтрэх хуудас руу шилжинэ. Энд СиСи эрхээрээ нэвтэрч ороход автоматаар системд нэвтэрнэ.


5. Баримтыг системд оруулах

Системд нэвтэрч орсны дараа сэжигтэй баримтыг (document file) шалгах үндсэн хуудас (Зураг 2) харагдах бөгөөд шалгах файлаа системд хуулж өгнө.

Дараах файлын төрлөөс сонгон системд шалгуулна уу.

- *Майкрософт оффис программын файлууд*: Жишээ нь *.doc, *.docx, *.xlsx, *.pptx гэх мэт.
- *Portable Document Format (PDF)*: PDF файл


Файлыг *Файл...* талбарын ард байрлах цаасны хавчаар зураг дээр дарж эсвэл өөрийн компьютерын файл хөтчөөс (жишээ нь, Windows Explorer) чирч веб хөтчид харагдах энэ хуудасны тасархай хүрээгээр хязгаарласан талбайд байрлуулснаар хийж гүйцэтгэнэ.



Зураг 2. Сэжигтэй баримтыг шалгах хуудас

6. Баримтыг шалгах

Баримтаа оруулсны дараа **Зураг 3-т** үзүүлсэн цонх гарч ирнэ. Энд таны хуулж буй файлыг бүрэн хуулж дууссан бол **ШАЛГАХ** товчлуур гарч ирнэ. Хэрэв та буруу файл хуулсан бол *өөр файл сонгох* холбоос дээр дарж өөр файл дахин хуулах боломжтой.



Зураг 3. Сэжигтэй файлыг системд хуулсны дараа шалгах хэсэг

Хэрэв файлыг шалгах бол ШАЛГАХ товчлуурыг дарж бүтээлийн хулгайн таамаглалыг харна. Үүний дараа **Зураг 4**-д үзүүлсэн цонх гарч ирнэ. Энд сэжигтэй баримтын хэдэн хувь нь бүтээлийн санд байгаа файлуудад хуулбарлагдаж орсныг харуулах ба хуулсан байж болзошгүй бичвэрийг хуудасны зүүн талд харуулна.

МУИС-Бүтээлийн хулгайг X

pds.num.edu.mn/plagia.html?sisilD=10011000855&fname=Амарсанаа%2B&lnf

Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем

Сэжигтэй баримт: a suspicious document.odt
Илгээсэн: 2015-12-18 12:46:45 AM EST
Шалгасан: Г.Амарсанаа

Энэ баримтын **32% бичвэр**
2 эх баримтад байна.

Бүтээлийн сангаас (2)

- 2% Ontology localization MMT-2015.pdf
- 2% oral 3 - Mongolian Open Data v4.pdf

Хамтын ажиллагаат орчуулга нь эхлээд өгүүлбэрийн үг бүрээр орчуулаад дараа нь Англи хос хэлтэй хэрэглэгчээр өгүүлбэрийг гүйцээж орчуулуулдаг.

Эцэст нь орчуулах хэлний хэрэглэгчид тухайн өгүүлбэрт тохирох хамгийн зөв орчуулгыг үнэлж тогтоожээ. Бүтээлийн баримт бичгийг индекслэж хадгалсан файлын сан байна.

Энд бүтээлийн санд хадгалах баримтын мета өгөгдлийг хадгална.

Энэ ажлаар өгүүлбэрийг бүхэлд нь нэг орчуулагчаар орчууулах бус өгүүлбэрийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт нягт хамтын ажиллагаатай орчуулгыг хийсэн нь гол ололт юм.

Ямар баримтаас хэдэн хувь хуулбарлагдсаныг тус бүрд нь харуулна. Дипломын ажил шалгахдаа энэ үзүүлэлтийг бодитой байгаа эсэхэд санал дүгнэлт өгнө үү.

Хуулбарлалтын голлох хувийг энд үзүүлнэ. Энэ үзүүлэлтийг бодитой байгаа эсэхэд санал дүгнэлтээ өгнө үү.

Хуулсан байж болзошгүй бичвэр

Зураг 4. Сэжигтэй баримтын бүтээлийн хуулбарлалтын таамгийг харуулах

Хуулсан байж болзошгүй бичвэрийн урд шар өнгөөр тэмдэглэж ялган харуулдаг. Хэрэв хуулсан байж болох бичвэр дээр дарвал тухайн бичвэр хэдэн хувь хуулагдсаныг харуулна. Жишээ нь **Зураг 5**-д тухайн бичвэр 96% адилхан байгааг харуулна. Үнэн хэрэгтээ зурагт үзүүлсэн жишээн дээрх бичвэрүүд хоорондоо яг ижил боловч Монгол хэлний нь гэх үг өгүүлбэрийн утгад нөлөөлдөггүй учир таамгийн бодолтоос хасаж тооцсон болно.

Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем

Ганболд Амарсанаа

Сэжигтэй баримт: a suspicious document.odt
Илгээсэн: 2015-12-18 01:04:41 AM EST
Шалгасан: Г.Амарсанаа

Энэ баримтын **32% бичвэр**
2 эх баримтад байна.

Бүтээлийн сангаас (2)

- 2% Ontology localization MMT-2015.pdf
- 2% oral 3 - Mongolian Open Data v4.pdf

Хамтын ажиллагаат орчуулга нь эхлээд өгүүлбэрийн үг бүрээр орчуулаад дараа нь Англи хос хэлтэй хэрэглэгчээр өгүүлбэрийг гүйцээж орчуулуулдаг.

Эцэст нь орчуулах хэлний хэрэглэгчид тухайн өгүүлбэрт тохирох хамгийн зөв орчуулгыг үнэлж тогтоожээ. Бүтээлийн баримт бичгийг индекслэж хадгалсан файлын сан байна.

Энд бүтээлийн санд хадгалах баримтын мета өгөгдлийг хадгална.

Энэ ажлаар өгүүлбэрийг бүхэлд нь нэг орчуулагчаар орчууулах бус өгүүлбэрийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт нягт хамтын ажиллагаатай орчуулгыг хийсэн нь гол ололт юм.

96%

Хуулсан байж болзошгүй бичвэрийг эх бичвэртэй харьцуулан харуулна. Энэ хэсэгт санал, дүгнэлтээ өгнө үү.

Зураг 5. Хуулсан байж болзошгүй бичвэр

Хэрэв нэг бичвэр хэд хэдэн баримтад олдвол тус тусад нь хуулсан байж болох хувийг бодож харуулна.

Мөн *Бүтээлийн сангаас* хэсэгт хуулсан байж болзошгүй баримтуудыг харуулах ба файлын нэрийн өмнө нь тухайн баримтаас хэчнээн хувийг хуулсан байж болохыг хувиар харуулдаг. Энэ файлын нэр дээр дарж тухайн файлаас ямар ямар хэсгийг хуулсныг харах боломжтой (**Зураг 6**).

The screenshot shows a web browser window displaying a plagiarism detection system interface. The browser address bar shows the URL: `pds.num.edu.mn/plagia.html?sisilD=10011000855&fname=Амарсанаа%2B&lname=Ганболд#`. The page title is "Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем" (System for preventing plagiarism of works). The user is identified as "Ганболд Амарсанаа".

The main content area displays the following information:

- Сажигтэй баримт: a suspicious document.odt
- Илгээсэн: 2015-12-18 01:13:11 AM EST
- Шалгасан: Г.Амарсанаа

A large red box indicates the similarity score: **37% бичвэр** (37% text). Below it, it says "2 эх баримтад байна." (Found in 2 sources).

On the right, a section titled "Бүтээлийн сангаас (2)" (From the work repository (2)) lists the detected sources:

- 4% Ontology localization MMT-2015.pdf
- 1% oral 3 - Mongolian Open Data v4.pdf

The main text area contains a detailed analysis of the document's structure and content, highlighting similarities with the detected sources. It notes that the document's structure (introduction, main text, conclusion) matches the sources, and that the content is highly similar, particularly in the main text and conclusion sections.

Зураг 6. Хуулсан байж болох файлын бүх бичвэрүүд



БҮТЭЭЛИЙН ХУУЛБАРЛАЛТЫГ ШАЛГАСАН ТУХАЙ ИЛТГЭХ
БАТАЛГААНЫ ХУУДАС

А. Ерөнхий мэдээлэл: Суралцагчийн бөглөх хэсэг

1. Суралцагчийн овог нэр

2. Бүртгэлийн дугаар

3. Бүрэлдэхүүн сургууль, тэнхим

4. Хөтөлбөрийн нэр

5. Цахим шуудангийн хаяг Утасны дугаар

| | |
|----------------------|----------------------|
| <input type="text"/> | <input type="text"/> |
|----------------------|----------------------|

6. Зэрэг

| | |
|------------------------------|-----------------------------|
| <input type="text"/> Магистр | <input type="text"/> Доктор |
|------------------------------|-----------------------------|

7. Удирдагч багшийн овог нэр, харьяалал

8. Албан тушаал

9. Цахим шуудангийн хаяг Утасны дугаар

| | |
|----------------------|----------------------|
| <input type="text"/> | <input type="text"/> |
|----------------------|----------------------|

10. Зэрэг цол

11. Судалгааны ажил, диссертацийн сэдвийн нэр (Доогуур нь зурах)

Б. Бүтээлийн хуулбарлалтыг шалгасан мэдээлэл: Суралцагчийн бөглөх хэсэг

| | | | | | |
|---|--|-----------------------------|--|--------------------------------|--|
| 1. Шалгасан огноо: | | 2. Нийт давхцалын хувь (%): | | 3. Давтагдсан эх баримтын тоо: | |
| 4. Хамгийн их хувьтай давхцал үүссэн баримтын тоо, дундаж хувь %: | | | 5. Хамгийн их давхцал үүссэн бичвэр хэсгийн тоо, дундаж %: | | |

Баталгаажуулалт:

“Бүтээлийн хуулбарлалтаас сэргийлэх систем”-ээр А.11-т дурдсан судалгааны ажлын бичвэрийг шалгасан бөгөөд дүн нь энд бичсэн үр дүнтэй ижил буюу үнэн бодитоор тэмдэглэсэн болохыг баталгаажуулж байна.

Суралцагч:

Хянасан удирдагч багш:

Гарын үсэг

Гарын үсэг

В.1. Бүтээлийг шалгах үе болон шалгасны дараах үеийн асуумж: Суралцагчийн бөглөх хэсэг. Жич: Жишээгээр тайлбарлаж бичнэ үү.

| | | |
|---|--|--|
| 1 | Та бичвэрээ хэдэн удаа энэ системээр шалгаж үзсэн бэ? Шалгах бүрд үр дүн нь ижил байсан уу? | |
| 2 | Гарсан үр дүн нь бодитой, хүлээн зөвшөөрөхүйц байж чадаж байна уу? Үгүй бол яагаад? | |
| 3 | Үр дүнг 3 хэсэгт гаргаж харуулсан нь өөр хоорондоо уялдаатай байж, нэг үр дүнд хурч чадаж байна уу? Үгүй бол яагаад? | |
| 4 | Системийн ажиллагаанаас шалтгаалсан асуудал, хүндрэл бэрхшээл гарсан уу? | |
| 5 | Өөр бусад асуудал, хүндрэл тулгарч, санал зөрчилдөх үе гарсан уу? | |
| 6 | Системийг цаашид сайжруулж хөгжүүлэх талаар та санал зөвлөмжөө бичнэ үү? | |
| 7 | Бусад санал, зөвлөмж | |

В.2. Системийн хэрэглээнд өөрийн үнэлгээг өгнө үү.

Үнэлгээний оноо: (Бага/хангалтгүй) 1 2 3 4 5 (Өндөр/хангалттай)

| | | |
|---|---|--|
| 1 | Системийг хэрэглэхэд ойлгомжтой, хялбар байдал | |
| 2 | Системийн мэдээллийн сангийн аюулгүй байдалд таны итгэл үнэмшил | |
| 3 | Систем ачаалж байх үед саадгүй, хэвийн ажиллах байдал | |
| 4 | Систем нь таны хэрэглээнд нийцэж буй байдал | |
| 5 | Системд өгөх таны ерөнхий үнэлгээ | |
| 6 | Бусад таны санал | |

Баталгаажуулалт:

Бүтээлийн хуулбарлалтыг системээр бүтээлээ шалгуулахад гарсан үр дүнд үндэслэж санал, дүгнэлтээ тайлбарлаж бичсэн нь үнэн болохыг баталгаажуулж байна.

Суралцагч:

Хянасан удирдагч багш:

Гарын үсэг

Гарын үсэг